



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 -ны өдөр

Дугаар А/11

Эрдэнэт

Сар шинийн баярын үеэр ажиллах ажлын
хэсэг томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.1-10.4.5, 11.3.4, Коронавируст(Ковид-19) халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны А/04 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сар шинийн баярын үеэр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Баярын өдрүүдэд шуурхай штаб дээр ажиллаж байгаа хариуцлагатай жижүүрүүдээс өдөр бүрийн мэдээллийг авах, шаардлагатай тохиолдолд шуурхай хуралдаан зарлах, шуурхай штабын менежерт цаг үеийн мэдээллийг хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээг өдөр бүр гаргаж Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, шуурхай штабын менежерт мэдээлэхийг Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн статистик дүн бүртгэгч /С.Эрдэнэцэцэг/-т даалгасугай.

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгслийг нөөцийг бэлтгэх, жижүүр эмч нарыг ээлж хүлээлцэхэд онцгой анхаарах, хариуцлагыг өндөржүүлэх, алсын дуудлага болон түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах, хариуцлагатай жижүүр томилон ажиллахыг БОЭТ-ийн захирал /Б.Батсүх/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.СҮХЭЭ



My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 02 дугаар сарын
.10-ний өдрийн 4/11 дугаар
тушаалын хавсралт



САР ШИНИЙН БАЯРЫН ҮЕЭР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Нэрс | Албан тушаал | Чиг үүрэг | Хугацаа |
|----|-----------------|-------------------|-----------|---|
| 1 | А.Баярхүү | СТҮХМэргэжилтэн | Ахлагч | 2-р сарын 11- нээс-2-р сарын 15-ныг дуустал |
| 2 | Б.Уртнасан | ЯГҮТҮХМэргэжилтэн | Гишүүн | |
| 3 | П.Хишгээ | ЭХТҮХМэргэжилтэн | Гишүүн | |
| 4 | Г.Энхжаргал | ХШҮДАХМэргэжилтэн | Гишүүн | |
| 5 | М.Ариунэрдэнэ | ХНМэргэжилтэн | Гишүүн | |
| 6 | Д.Отгондэлгэр | Эдийн засагч | Гишүүн | |
| 7 | Н.Чулуун-Эрдэнэ | Ерөнхий нягтлан | Гишүүн | |
| 8 | Х.Оюунэрдэнэ | МТТМХМэргэжилтэн | Гишүүн | |
| 9 | Г.Итгэл | Статистикч | Гишүүн | |
| 10 | Б.Билгүүн | ХӨТСХМэргэжилтэн | Гишүүн | |